

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2024.01.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн XVIII, XIX хуралдаан 2023 оны 12 дугаар сард хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын XVIII хуралдаанаар:

1.Сэлэнгэ аймгийн 2023 оны тодотгосон төсөв батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн 2023 оны төсвийн нийт орлогыг 22.115.000.00 төгрөгөөр, аймгийн төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 22.904.663.5 мянган төгрөгөөр тус тус тодотгон баталлаа.

2. Сэлэнгэ аймгийн 2024 оны төсөв батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн төсвийн орлогыг 29.938.900.9 мянган төгрөгөөр, төсвийн зарлагыг 25.802.100.3 мянган төгрөгөөр тус тус баталлаа.

3.Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэн батлав.

Аймгийн ИТХ-ын XIX хуралдаанаар:

1. 2024 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай асуудлыг хэлэлцээд нийт 3222 иргэнд 491.3 мянган га газрыг өмчлүүлэхээр сум тус бүрээр хэлэлцэн батлав.

2.Суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг шинэчлэн тогтоох, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх санал уламжлах тухай асуудлыг хэлэлцэн батлав.

3.Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийг хэмжээг шинэчлэн баталлаа.

4.2024 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод түлээ бэлтгэх хуваарийг батлав.

5.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Сүхбаатар сумын 4-р цэцэрлэгийн 80 жилийн ойг 2024 оны 09 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

6.Мөн ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Ерөө сумын 1-р цэцэрлэгийн 70 жилийн ойг 2024 оны 09 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.

7.Сүм хийдийн зөвшөөрлийн хугацаа сунгах тухай асуудлыг хэлэлцээд Баруунбүрэн суманд үйл ажиллагаа явуулж буй Амарбаясгалант хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгалаа.

Аймгийн ИТХ-ын Зөвлөл хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1.Аймгийн 2024 оны төсөв батлах тухай

- 2.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай
 - 3.Аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийх тухай
 - 4.2024 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил хэмжээг батлах тухай
 - 5.Суурин газрын суурьшлын бүсийн тэг гортигийг шинэчлэн тогтоох, газрын нэгдмэл сангийн ангилал шилжүүлэх санал уламжлах тухай
 - 6.2024 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай
 - 7.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай
 - 8.Зөвшөөрлийн хугацаа сунгах тухай
 - 9.2021-2023 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн тухай
 - 10.2021, 2022 онд “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ”-ний хүрээнд хийгдсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнгийн тухай
 - 11.Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн явцын мэдээлэл
- Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, иргэд олон нийтийг үер, усны гамшигт өртөхөөс сэргийлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур, Хушаат сумдын усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоох, мөн хамгаалалтын бүсэд орсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд сонсох ажиллагааг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Нутгийн удирдлагын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт 12 дугаар сарын 04-ний өдөр Сүхбаатар хотноо зохион байгуулагдаж, 70 гаруй төрийн албан хаагч хамрагдлаа.

12 дугаар сарын 09-ний өдөр "Гадаад харилцааг эдийн засагжуулах нь" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын гишүүн Ч.Ундрамын урилгаар БНХАУ-ын Тяньжины гадаад хэлний их сургуулийн Хятад - Монголын судалгааны төвийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Лю Пен, ХААИС-ийн захирал, профессор Б.Баасансүх нарыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар боловсрол, хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлал, аж үйлдвэр, хилийн худалдаа зэрэг өргөн агуулгын хүрээнд ярилцаж, харилцан газар дээр нь туршлага судлахаар тохиролцлоо.

Улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний хязгаарлалтын горимд шилжих болсонтой холбогдуулан 12 дугаар сарын 13-ны өдөр “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ дээр ажиллаж, шуурхай арга хэмжээ авах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдалд хэрхэн ажиллах талаар тус байгууллагын удирдлага, инженерүүдтэй уулзаж зөвлөлдлөө.

12 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд Баруунбүрэн, Хушаат, Орхон, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, малчдын төлөөлөлтэй уулзлаа.

Сэлэнгэ аймгийн соёлын байгууллагуудын албан хэрэгцээнд зориулан шинэ тоног төхөөрөмж нийлүүлж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүллээ. Мөн “Сэлэнгийн Долгио Чуулга”-д аймгийн төсвийн 199,7 сая төгрөгийн хөрөнгөөр “Мэргэжлийн дуу бичлэгийн студи”-ийг байгуулж, соёл урлагийн уран бүтээлчид аймаг орон нутагтаа дуу хоолойн бичлэгт орох боломж бүрдлээ.

2023 оны “Онцлох хүүхэд”-ийг 9 төрөлд үндэслэн тодруулж, алдаршууллаа.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Гамшиг ослын дуудлагын талаар

Тайлангийн хугацаанд объектын гал түймрийн 8 удаагийн дуудлагаар иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 110 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалж ажилласан.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр

Гэр хорооллын айл өрхүүдэд гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Баянгол, Мандал, Сайхан, Сүхбаатар, Хүдэр сумын 457 гэр хорооллын айл өрхийн 1257 иргэнд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, анхааруулга санамжийг өгсөн.

Урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг материал, зөвлөмжийг “Объектын гал түймрээс урьдчилан сэргийлье”, “Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ”, “Хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлье”, “Пиротехникийн хэрэгслийн зохистой хэрэглээ” сэдвээр бэлтгэн 243 иргэнд тарааж ажиллалаа.

Ажлын байрны дүгнэлт олгосон байдал:

Тайлант үед 7 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчлийг арилгасан 4 объектод ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож 200,000 төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд тушаалгаж ажилласан.

Барилга байгууламжийн зураг төсөл хянасан байдал:

Төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 4 ажлын зургийг хянаж Онцгой байдлын газрын даргаар баталгаажуулан дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн 200.000 төгрөгийн хураамжийг сумын төрийн сангийн дансанд тушаалгаж ажилласан.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар:

Төсөв санхүүгийн чиглэлээр: Тайлант хугацаанд өссөн дүнгээр улсын төсвийн шилжүүлгээр 322,632.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 72,000.0 мянган төгрөг нийт 394,632.9 мянган төгрөгийн санхүүжилт тавигдсанаас батлагдсан төсвийн зориулалтын дагуу төсвийн тухай хууль, НББ-ийн холбогдох дүрэм журамд нийцүүлэн зарцуулж, холбогдох тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж, санхүүгийн бүртгэлд тусган ажиллаж байна.

Хугацаатай бичгийн шийдвэрлэгдсэн байдал: Энэ сард нийт 23 бичиг ирснээс 10 хугацаатай бичиг ирж 10-г хугацаанд нь бүрэн шийдвэрлэн холбогдох хариуг илгээсэн байна.

Тулгамдаж буй асуудал: Тус хэлтэс нь өөрийн албан конторын байр байхгүй, Нийгмийн даатгалын хэлтсийн байранд түрээсээр үйл ажиллагаа явуулдаг тул төрийн үйлчилгээний чанар хүртээмж, эталон тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэх, иргэдийн ая тухтай орчин нөхцөлд үйлчилгээ авах, ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад хүндрэл бэрхшээлтэй байна.

Үйлчилгээний баталгаажуулалт: Сүхбаатар, Жавхлант, Хушаат, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Орхон, Сайхан, Мандал, Шаамар, Түшиг, Хүдэр, Цагааннуур, Бугант тосгон, Ерөө сумын 70 иргэн, аж ахуйн нэгжийн 73 үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж, “MNS 5021-1:2019 Жижиглэн

худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага”, “MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага”, стандартын шаардлагад нийцсэн **62** үйлчилгээний газарт баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж тохирлын гэрчилгээ олгосон.

Экспорт баталгаажуулалт: Ерөө суманд Болдтөмөр Ерөө гол ХХК, Инфинити спэйс ХХК хэмээх **2** аж ахуй нэгжийн олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал- MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн **59** удаагийн тээвэрлэлтэд баталгаажуулалт хийж, экспортын гэрчилгээ олгосон байна.

Стандарт, мэдээллийн салбар сангаас **6** аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 5 нэрийн **10** стандартын борлуулсан байна.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: 4 шатахуун түгээх станцын 12 шатахуун түгээгүүрийн шингэн хэмжигчийг шалган баталгаажууллаа.

Итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 68 аж ахуй нэгжийн 281 дээжид 568 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 5 аж ахуй нэгжийн 12 дээж 31 үзүүлэлтээр шаардлага хангахгүй гарч, нийт дээжийн 4.27 %-г эерэг сорьц эзэлж байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

12 сард 5727 баримтаар 27,3 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн вэб сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		113,387,268.7	81,289,508.6	578.1
1.1	Орон нутгийн төсвийн орлого	51,787,164.8	29,906,907.7	57.7
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	22,827,810.0	17,702,789.1	77.5
	Сумдын төсвийн орлого	28,959,354.8	12,204,118.6	42.1
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	5,465,393.0	4,943,085.4	90.4
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	15,258,305.2	15,258,305.2	100.0
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	8,255,036.8	8,255,036.8	100.0
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	2,735,242.2	2,735,242.2	

1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,505,807.6	1,651,863.7	109.7
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	2,902,447.1	1,553,452.5	53.5
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		113,387,268.7	49,548,403.2	43.7
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	113,387,268.7	49,548,403.2	43.7
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	53,682,900.3	9,908,818.7	18.5
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	15,921,815.3	10,174,204.9	63.9
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	43,782,553.1	29,465,379.6	67.3
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	8,049,812.8	3,702,125.3	46.0
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	9,556,056.7	6,811,410.2	71.3
	Халамжийн сан	138,600.0	101,539.0	73.3
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	20,370,949.2	16,004,037.5	78.6
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	1,055,273.8	1,046,952.6	99.2
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	4,611,860.6	1,799,315.0	39.0
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		16,181,984.7	13,437,338.2	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	6,625,928.0	6,625,928.0	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	9,556,056.7	6,811,410.2	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	9,556,056.7	6,811,410.2	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд			
	Усан хангамжийн татаас	-	-	-
4. Тусгай сангуудын зарлага		2,902,447.1	1,553,452.5	53.5

4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	2,902,447.1	1,553,452.5	53.5
-----	--------------------------	-------------	-------------	------

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 – XI	2023 – XI	<u>2023 - XI</u> <u>2022 - XI</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /Алтантараи, I зэрэг, кг/	2 100	2 600	123.8
	Талх /орон нутгийн, ш/	1 700	2 200	129.4
	Нарийн боов /кг/	5 500	5 500	100.0
	Будаа /кг/	3 600	3 600	100.0
	Элсэн чихэр /кг/	3 300	4 500	136.4
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	8 000	10 000	125.0
	Үхрийн мах /кг/	10 000	11 500	115.0
	Адууны мах /кг/	8 000	11 000	137.5
	Ямааны мах /кг/	7 500	8 500	113.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	8 000	8 000	100.0
	Хиам /чанасан, кг/	17 100	16 000	93.6
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	2 000	2 000	100.0
	Сүү / савласан, л/	4 800	4 500	93.8
	Тараг /задгай, л/	2 800	2 800	100.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	23 000	92.0
	Айраг /л/			
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	6 600	8 000	121.2
	Өндөг /ш/	500	500	100.0
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	11 000	10 500	95.5
	Өөхөн тос /кг/	3 000	4 000	133.3
	Шар тос /кг/	25 000	26 000	104.0
	Масло /задгай, кг/	7 500	8 500	113.3
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 500	1 700	113.3
	Лууван /кг/	2 500	2 500	100.0
	Манжин /кг/	2 500	3 000	120.0
	Байцаа /кг/	2 500	2 500	100.0
	Сонгино /кг/	2 800	3 000	107.1
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	7 500	8 500	113.3
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	5 250	5 500	104.8
2. ШАТАХУУН				

Бензин А - 80	2 480	2 480	100.0
Бензин А - 92	2 500	2 500	100.0
Дизелийн түлш	3 760	3 980	105.9

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн яам, Монголын нотариатчидын танхимтай хамтран зохион байгуулж буй сумдын нотариатын үүрэг хавсран гүйцэтгэгч нарт зориулсан онлайн сургалтыг зохион байгууллаа.

Авлигын эсрэг хууль тогтоомж, Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг Бугант тосгоны нийт төр, төсвийн байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан.

Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний зөвлөлийн ажлын албанаас 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан эрх зүйн хөтчийг чадавхжуулах цахим сургалтад 17 албан хаагч хамрагдаж эрх зүйн хөтчийн анхан шатны сертификат авсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: 2023 оны 12 дугаар сард иргэний шийдвэр гүйцэтгэх тасагт 18,900,000 төгрөгийн 50 гүйцэтгэх хуудас ирж, 7,500,000 төгрөгийн 7 гүйцэтгэх хуудсыг хааж, 735 гүйцэтгэх хуудсыг хяналтдаа авч ажиллаж байна. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр шийтгэгдсэн 26 гүйцэтгэх хуудас ирж, 14 гүйцэтгэх хуудас хааж, 215 гүйцэтгэх хуудсыг хяналтдаа авч ажиллаж байна.

Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс: 2023 оны 12 дугаар сард шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 10, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо 5, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр эд мөрийн баримтын тоо 33, криминалистикийн шинжилгээ 9, цогцост хийсэн шинжилгээний тоо 5-г хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс:

2023 оны 12 дугаар сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 146 /эрэгтэй-68, эмэгтэй-78/
- Гэрлэлтийн бүртгэл - 33
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 6
- Үрчлэлт - 6
- Эцэг, эх тогтоолт – 7 /үүнээс эрэгтэй 6, эмэгтэй 1/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 5
- Нас баралт - 47
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 354
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 136
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 40
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 178
- Гадаад паспорт олголт - 353
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 201 /үүнээс насанд хүрсэн 121, хүүхэд 80/
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 132 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 368
- Анхны бүртгэл - 105
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 73

- Барьцааны гэрээ - 169
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 13
- Лавлагаа хуулбар - 5
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 189

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 474
- Анхны бүртгэл- 25
- Өмчлөх эрх шилжих гэрээ- 81
- Барьцааны гэрээ- 336
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 11
- Лавлагаа хуулбар-5
- Нийт бичигдсэн гэрчилгээ-114

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн чиглэлээр: Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээг хамруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

- Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн комисс нь 2023 оны ээлжит хурлаар хүсэлт ирүүлсэн 5 байгууллагын ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгаж, чиглэл нэмэх 1 байгууллагын хүсэлтийг шийдэж, өөрийн хүсэлтээр 1 байгууллагын үйл ажиллагааг цуцалсан.

- 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумын 32 иргэн, аж ахуйн нэгжид, Мандал, Баруунбүрэн, Хушаат, Зүүнбүрэн, Орхонтуул, Сайхан, Сант, Хүдэр, Ерөө, Жавхлант, Түшиг сумдаас 83 иргэн, аж ахуйн нэгж нийт 14 сумын 114 төлөөлөл бүхий албан тушаалтан, иргэдэд “Хүнсний худалдаа, үйлчилгээний газарт мөрдөгдөх эрүүл ахуйн нөхцөл, шаардлага, анхаарах асуудал” сэдвийн хүрээнд танхим болон цахим хосолсон сургалтыг хамтран хийж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч хамтран ажиллалаа.

- 2023 оны Дэлхийн ДОХ өвчинтэй тэмцэх өдрийг “Олон нийтийн манлайллыг дэмжье” уриатай бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд зохион байгууллаа. Тус өдөр МСҮТ, ЕБС-ын сурагч, төр хувийн хэвшлийн ажилтан албан хаагч нар, иргэдэд чиглэсэн ХДХВ/ДОХ-ын талаарх эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, АХА, дэвжээ, алтан хонх зэрэг олон талт арга хэмжээг явуулж нийт 2970 хүн хамруулсан байна. Мөн цахим сүлжээгээр давхардсан тоогоор 8 төрлийн мэдээллийг 1200 гаруй иргэнд хүргэсэн ба сургалт, тэмцээн уралдаан оролцогч, иргэдэд 1000 гаруй гарын авлага, 500 бэлгэвч тараасан.

- “Эх, нярай, нөхөн үржихүйн эрүүл мэнд” хоёр өдрийн онол, дадлага хосолсон сургалт нийт 32 эх баригч нарыг хамруулсан.

Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:

Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Дизайн технологийн /эрэгтэй/ кабинетын сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Дижитал технологийн хэрэглээ, лазер зүсэгч машины туршилт, ашиглалт” сэдэвт сургалтыг 2023 оны 12 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтыг МУБИС-ийн багш, доктор

профессор Д.Сэрээтэрдорж, багш М.Баасанбаяр нар БШУГ-тай хамтран явуулж, 18 сургуулийн 30 багшийг хамруулан сертификат олгов.

- "Сайн хичээл, хөтөлбөр, хэрэглэгдэхүүн" уралдааныг зохион байгуулж, 22 багш оролцож, 8 багийн хамтарсан хичээл зааж, хэлэлцүүлэг өрнүүлэн зөвлөгөө өгч ажиллалаа.

- Бэлчир болон Ерөө бүсийн гадаад хэлний багш нартаа "Гадаад хэлний хичээлээр сурагчдад зүрх сэтгэлийн боловсрол олгох арга зүй" сэдэвт сургалтыг U.S. Embassy - Ulaanbaatar, Mongolia санхүүжилттэй хэрэгжиж буй #ETM7 ментор багш бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 37 багшийг оролцуулан, зохион байгууллаа.

Соёл урлагийн чиглэлээр:

Биеийн тамир, спортын чиглэлээр: Биеийн тамир, спортыг дэмжих замаар хүний хүний дундаж наслалтыг уртасгах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

- Нутгийн удирдлагын 30 жилийн ойн арга хэмжээнд зориулан Үндэсний бөхийн улс, аймгийн цолтой 64 бөхийн барилдааныг зохион байгууллаа.

- "Сурагч лиг" Сагсан бөмбөгийн тэмцээн 2023 оны 10 дугаар сарын 07-с 12 дугаар сарын 17-ыг дуустал зохион байгуулж, нийт 13 сургуулийн 195 сурагч тамирчид оролцлоо.

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн чиглэлээр: Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих, тэднийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан байна.

Үүнд:

- Хүүхдийн өөрийн сонирхолд тулгуурласан, хүүхдийн оролцоог дэмжсэн, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, авьяас чадвараа нээн илрүүлэх зорилттойгоор Мандал сумын хүүхдийн ордноор 5 төрлийн дугуйланд 103 хүүхэд, Орхонтуул хүүхэд хөгжлийн төвөөр 6 төрлийн дугуйланд 39, байгууллагын дэргэдэх 2 төрлийн дугуйланд 11, нийт 153 хүүхэд хамрагдсан.

- Шүүхийн захирамжаар албадлагын арга хэмжээ авсан 8 иргэнд зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн сургалтыг "Гэр бүлийн харилцаа" сэдвээр зохион байгуулсан.

- Шүүхийн захирамжийн дагуу хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлтийг 1 өрхийн 2 насанд хүрэгч, 2 хүүхдээс "шүүхийн журмаар гэр бүл цуцлахад хүүхдийн асран хамгаалагч тогтоох нэгдсэн арга зүйн гарын авлага" сэтгэл зүйн 14 багц оношилгооны тестийг авч, нөхцөл байдлын үнэлгээ хийлээ.

- Ерөнхий боловсролын сургуулийн 1-4 дүгээр ангийн 250 сурагчдад үе тэнгийн найз нөхдөө хэрхэн хайрлах талаар сургалт зохион байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал чиглэлээр: Иргэний аж ахуй эрхлэх ур чадварыг хөгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажилтай орлоготой болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Нийт 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс 1995-2005 оны 354 лавлагааны хүсэлтийг цахимаар хүлээн авч 349 лавлагааг гарган хугацаанд хүргүүллээ. Мөн аймгийн 17 сумын 619 иргэд даатгуулагчаас лавлагааны хүсэлтийг авч нийт 973 лавлагааг хугацаанд гаргаж ажиллаа.

- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь энэ 12 сард суурин 4 удаа хуралдаж нийт 341 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 21 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож, 305

иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 15 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Мал эмнэлгийн чиглэлээр:

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 15120 кг үхрийн махны 126 дээж, 1170 кг адууны 13 дээж, 777 кг хонины махны 37 дээж, 460 кг ямааны махны 23 дээж, 200 кг сүү, сүүн бүтээгдэхүүний 8 дээж ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн. Ариун цэвэр нян судлалын шинжилгээг Импортоор 21 ААНэгжийн гахайн мах 399,9 тн, тахианы мах 151,7 тн, зөөлөн чихэр 18,5 тн, өндөг загас 22,9тн буюу нийт 59,5 тн 5 төрлийн бүтээгдэхүүний 33 сорьц дээжид тус тус эмийн бодисын үлдэгдэл, уургийн задрал болон бусад магадлан шинжилгээг олон улсын стандарт арга зүйн дагуу тус тус шинжилж баталгаажуулж, холбогдох газарт шилжүүлсэн.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Тайлант хугацаанд 9 сумын 109 нэгж талбарт газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулахаар газрын биржийн цахим системд байршуулснаас 9 сумын газар эзэмших, ашиглах эрхийн нийт 92 дуудлага худалдаа амжилттай зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд 17 сумын 2043 нэгж талбарт улсын тэмдэгтийн хураамжийн нэхэмжлэл үүсгэн татварын удирдлагын нэгдсэн системд илгээснээс 1182 нэгж талбарын нэхэмжлэлийн дагуу нийт 11.8 сая төгрөгийн төлбөр хийгдэж, төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 37 аж ахуйн нэгж байгууллагын 37 объектод хяналт шалгалт хийж, 201 зөрчлийг илрүүлэн 33 аж ахуй нэгжид 195 заалт бүхий албан хугацаатай шаардлага хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Хяналт шалгалт хийсэн тухай танилцуулга, холбогдох тайлан мэдээг нэгтгэн баталгаажуулж салбарын хяналтын газруудад хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Зургаа. Сум, орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Харилцан хүндэтгэе-2023” өдөрлөг зохион байгуулж 50 иргэн оролцсон.

“Цайны зам ба Маймаачин хот”-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг Дэлхийн ЮНЕСКО-д бүртгүүлэх судалгааны ажлын хэсгийн бага хурлыг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

Дархлалын олдмол хомсдолтой тэмцэх өдрөөр сургуулийн эмч, сэтгэл зүйчтэй хамтран 6-9 дүгээр ангийн суралцагчдад сургалт явуулж, багш, ажилчдад эрүүл амьдралын хэв маягийг эзэмшүүлэх зорилго бүхий эрүүл мэндийн “Жаргалан” клубийн үйл ажиллагаагаа явуулж эхэллээ.

Бага ангийн суралцагчид гэрээсээ цахимаар хичээллэж байгаатай холбогдуулан хүүхдэдээ тавих анхаарал халамжаа нэмэгдүүлэх, их осол гэмтэлд өртөхгүй байх ахуйн хүрээний осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хүргэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 32 сурагчид “Угийн бичиг” хөтлөх сургалт хийж, АХА тэмцээн зохион байгууллаа.

Төр, төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд “Алтан лийр-2023” урлагийн наадам зохион байгуулагдлаа.

Баруунбүрэн сум

Сумын хэмжээнд 24 аж ахуй нэгж, 15 иргэн 11200 га талбайд уриншийн боловсруулалт хийж энэ онд 11148 га талбайд улаан буудай, 80 га талбайд овьёос, 50 га талбайд вандуй, 609 га талбайд тэжээлийн ургамал, 3383 га талбайд тосны ургамал тариалсан. 2023 онд сумын хэмжээнд 193142 толгой мал буюу тэмээ 36, адуу 14045, үхэр 22749, хонь 102335, ямаа 59977 өвөлжих байна. Өвөлжилтийн бэлэн байдлын нөхцөлд шилжин ажиллаж байна.

Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан операторын горимоор үзүүлэх үйлчилгээг e-mongolia.mn хаягаас 185 иргэн 185 лавлагаа мэдээлэл, 6 аж ахуйн нэгж, тоон гарын үсгээр 7 лавлагааг авсан байна. Нийт 37 иргэнд И-монголиа апп-ыг хэрхэн хэрэглэх, ашиглах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн.

“Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллого зохион байгуулах” ажлын хэсгийг байгуулж 2023 оны 12 дугаар сарын 07-аас 17-ны хооронд жилийн эцсийн Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг амжилттай зохион байгууллаа.

Баянгол сум

Тогтвортой хөгжлийн төлөөх бүтээлч үйлдвэрлэлийн үр шимийг таниулах, сурталчлах зорилгоор зохион байгуулсан орон нутгийн баялаг бүтээгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн “Баянголын брэнд” үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгууллаа.

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогыг 16 чиглэлд 64 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн. 2023 онд сумын хэмжээнд адуу-14006, үхэр 21801, хонь-76907, ямаа-47031 нийт 159745 толгой мал тоологдсон байна.

Идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж 12 иргэнийг байнгын, 3 иргэнийг түр байраар хангасан. Энэ сард ажилгүйдлийн бүртгэлд ажил хайгч 2 иргэн бүртгүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэгт хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг дэмжих санхүүгийн дэмжлэгт өвлийн хүлэмжийн чиглэлээр 1 иргэнд 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.

2023 онд 5681 га-д улаан буудай тариалж 8725 тн ургац хураан авсан ба 9 дүгээр сард ахуй хэмжээний хур тунадас орсны улмаас буудайн чанарт сөргөөр нөлөөлж, түрүүндээ болон талбайд ангилсан будаа их хэмжээгээр соёолсны улмаар улаан буудайн борлуулалт удаашралтай байна. Энэ сарын байдлаар 767 тн улаанбуудайг үрэнд авч, Хөдөө аж ахуй корпорацад 955 тн, Улаанбаатар гурил ХХК-д 2130 тн, Өгөөж гурил ХХК-д 213 тн, Өег гурил ХХК-д 1776,7 тн Апу ХХК-д 255 тн борлуулж, 4555 тн буудай үтрэм дээр байна.

Ерөө сум

2023 онд жилийн эцсийн мал тооллогоор 85167 толгой мал тоологдож 8223 толгой буюу 8.8 хувиар буурсан байна. Тус бүрээр авч үзвэл :

-Адуу 112 толгой буюу 1.4 хуваарь өссөн.

- Үхэр -544 толгой буюу 2.6 хуваарь буурсан.
- Хонь -3559 толгой буюу 10 хуваарь буурсан.
- Ямаа -4187 толгой буюу 14 хуваарь буурсан.

Хоршоо жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор “Бест хөгжлийн шийдэл ТББ”-аас “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн төсөл хөтөлбөрт хамрагдах тухай сургалт. “Цэнхэр харгиа ТББ”-аас “Харилцаа эерэг хандлага, маркетинг санхүү”-гийн сургалтыг сумандаа зохион байгуулж 27 иргэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоод, худалдаа үйлчилгээний аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрууллаа.

Хүүхдийн эрхийн тухай хуулийг сурталчлах, хүүхдийн дуу хоолойг сонсож хүүхдээс гарсан санал санаачилгыг дэмжиж ажиллах, хүүхдийг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө нээн илрүүлэхэд сургах зорилготой “Хамтдаа хэлэлцье” хүүхдийн чуулганыг Т.Бямбаагийн нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хүүхдийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан ба 6-12 дугаар ангийн 100, 1-р цэцэрлэгийн 20 нийт 120 сурагч хүүхдүүд оролцлоо.

Жавхлант сум

"Угийн бичгээ хөтөлж-Ураг удмаа мэдэцгээе" аяны хүрээнд ГУРВАН ЦАГИЙН ХЭЛХЭЭС уралдааныг зохион байгууллаа. Үүнд 14 сум, 3 тосгон оролцоо.

1. "Шилдэг тосгон" төрөлд Дулаанхаан тосгон шалгарлаа.
2. "ШИЛДЭГ БАГ" төрөлд Жавхлант сумын Бумбат баг шалгарлаа.
3. "БИ УГАА САЙН МЭДНЭ" төрөлд Орхон сумын 1-р цэцэрлэгийн эрхлэгч 3.Туяацэцэг шалгарлаа.
4. "БҮТЭЭЛЧ УГИЙН БИЧИГ" төрөлд Орхон сумын 1-р цэцэрлэгийн нягтлан бодогч 3.Ганзаяа шалгарлаа.
5. "УГИЙН БИЧГИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭГЧ" төрөлд Монголчуудын Угийн бичгийн академийн Сэлэнгэ салбар зөвлөлийн тэргүүн, сургагч багш Х.Дүнгээ шалгарлаа.

Сумын Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Ц.Дарханбаатар “Улс тунхагласны баяр”-ыг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийн хүүхдүүдтэй уулзаж “Тусгаар тогтнол, эрх чөлөө” сэдэвт илтгэл, ярилцлага хийлээ.

Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд асан, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатын санаачилгаар төгсөх ангийнханд зориулсан элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх номыг сумын 12-р ангийн сурагчдад гардуулан өглөө.

УИХ-н гишүүн Д. Өнөрболорын ивээл дор зохион байгуулагдсан "Алтан буудай-2023" урлагийн их наадамд Сэлэнгэ аймгийн 500 гаран хүүхэд багачууд 2 өдрийн турш авьяас билиг, ур чадвараа сорин өрсөлдлөө.

Зүүнбүрэн сум

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хүрээнд 6-12 дугаар ангийн сурагчдад Сэлэнгэ аймгийн Насан туршийн боловсролын нэгжийн багш нар 3 удаагийн цуврал сургалт зааж 75 сурагч, 9 дүгээр ангийн 23 сурагчдад Монгол Улсад эрэлт хэрэгцээтэй мэргэжил сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан. 12 дугаар сард багш нарын “Сурган хүмүүжүүлэх” илтгэлийн уралдаан амжилттай зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Засгийн газрын “2023 онд иргэдэд өмчлүүлэх газрын байршил, талбайн хэмжээг тогтоох тухай” 105 дугаар тогтоолын дагуу 2023 онд гэр, орон сууц

хашааны зориулалтаар иргэдэд өмчлүүлэхээр төлөвлөсөн байршлаас 13 иргэнд 12,740,000 төгрөгийн үнэ бүхий 0.91 га газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлсэн.

12-р сарын 7-17-ны хооронд “Мал, тэжээвэр амьтан, худаг”-ын ээлжит тооллогын ажлыг зохион байгуулж 79937 толгой мал тоолуулж, дүн мэдээг аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлж ажилласан.

Мандал сум

“Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд Мандал сумын ерөнхий боловсролын сургууль болон Зүүнхараа Политехник коллеж, цэцэрлэгийн багш нарын дунд “Ур чадвар-2023” уралдааныг зохион байгууллаа.

НҮБ-аас жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдрийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах “ өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэхүү өдрийг тохиолдуулан “Хөгжлийн бэрхшээл ба тэгш оролцоо” гар зургийн уралдааныг сумын ерөнхий боловсролын сургуулийн 6-8 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Хүнсний худалдаа эрхлэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх, арга зүйн мэдлэгийг дээшлүүлж, зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Татварын хэлтэстэй хамтран “Хүнсний худалдаа, үйлчилгээний чиглэлээр анхаарах асуудал, хууль тогтоомжийн хэрэгжилт”, “Ургамал, ургамлын гаралтай худалдаа үйлчилгээнд тавигдах хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт”, “Худалдаалах газарт мөрдөгдөх эрүүл ахуйн нөхцөл шаардлага, анхаарах асуудал”, “Стандартыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал”, “Зээлийн батлан даалтын сан”, “E-barimt олголт”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” сэдвээр танхим болон цахим хосолсон сургалтыг зохион байгуулж, тус сургалтад 35 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан.

АНУ-ын хөрөнгө оруулалттай олон улсын хөгжлийн агентлагийн BEST төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран 16 хоршооны гишүүдэд төсөлд хэрхэн хамрагдах аргачлалын талаад сургалт зохион байгуулсан.

Улсын хэмжээнд мал тооллогын арга хэмжээ 2023 оны 12-р сарын 07-оос 17-ны өдрүүдэд зохион байгуулагдаж тус сумын 2130 малтай өрхийн тэмээ-13, адуу-17693, үхэр-38773, хонь-28121, ямаа-29150, нийт 113755 толгой мал тоологдсон нь өмнөх оны мөн үетэй 10 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Орхон сум

Мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд иргэд, олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг фото мэдээлэл, шторк, сурталчилгаа хэлбэрээр “Сэлэнгэ Орхон сум ЗДТГ”, “Сэлэнгэ аймгийн Орхон сум”, “Нарт Орхоны хүүхдүүд”, “Selenge Orhon Emt” зэрэг албан ёсны фейсбүүк хаягуудад байршуулан 17 удаагийн мэдээ мэдээллийг хүргэж давхардсан тоогоор 565 иргэний хандалтыг авсан байна. Мөн иргэд, малчид, тээвэрчдэд зориулан Орхон цаг уурын станцаас цаг агаарын урьдчилсан мэдээг 5 хоног тутам тогтмол хүргэж байна.

Сумын хүүхдийн “Хамтдаа оролцъё-Хамтдаа хөгжье” IV чуулган зохион байгуулагдаж 7-12 дугаар ангийн 116 хүүхэд оролцлоо. Сурагчид 5 багт хуваагдан хүүхдийн хөгжил оролцоо, эрүүл мэнд, хүүхэд-хүүхэд, эцэг эх хоорондын харилцаа, боловсрол гэсэн 5 чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлэн сумын удирдлага, хүүхдийн төлөө зөвлөлд дуу хоолойгоо хүргэлээ.

Улс тунхагласны баярыг тохиолдуулан Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор 21 жилдээ зохион байгуулагдаж буй “Иргэний андгай өргөх ёслол”-д ерөнхий боловсролын сургуулийн 16 хүүхэд оролцож, “Батламж” гардууллаа.

Орхонтуул сум

Орхонтуул ЗДТГ, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум фейсбүүк хуудас, Рашаант тосгон зарын групп, Рашаант тосгон захирагчийн алба фейсбүүк хуудас болон Orkhontuul.se.gov.mn веб сайтад 12 төрлийн урьдчилан сэргийлэх болон цаг үеийн мэдээлэл, 5 шторкийг бэлтгэн байршуулсан.

Мөн хүүхдийн эрхийг хангах, хүүхдийн эрх зөрчигдөх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийлэл дарамтаас ангид байх, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс “Хүүхдэд ээлтэй хүчирхийлэлгүй сум” аяныг өрнүүлэн төр, төсвийн байгууллагууд гадна дотно орчинд засвар үйлчилгээг тогтмол хийж гамшгийн үед ажиллуулах дуут дохиолол, гадна камер байрлуулах дэлгэц зэргийг бэлтгэн байрлуулсан байна.

Тухайн сард мал эмнэлгийн 686 гэрчилгээ бичигдсэнээс амьтан хэрэгцээлэхэд 97, бүтээгдэхүүнээр 557, үржлээр 29 гарал үүсэл бичигдсэнд хяналт тавьж баталгаажуулж ажилласан. Мал, амьтныг гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтад шаардагдах 30900 тун вакциныг хүйтэн хэлхээний горимыг баримтлан татан авч МЭҮН-үүдэд төлөвлөгөөний дагуу хуваарилан хэрэгжилтэд хяналт тавьж 30829 толгой мал, амьтныг хамруулан ажилласан. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх ажлын хүрээнд угаалгад 54729 толгой, туулгалтад 60130 толгой, боловсруулалтад 48862 толгой малыг хамруулан ажиллаад байна.

Сайхан сум

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар Томуу томуу төст өвчний тархалт улсын хэмжээнд “идэвхжил” –ийн түвшинд, 4 аймагт “Алаг цоог дэгдэлт” – ийн түвшинд шилжсэнтэй холбогдуулан сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран иргэдэд бүр ханиад томуунаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, гарын авлага бэлтгэн, хүн бүр маскаа зүүж өөрийгөө болон бусдын эрүүл мэндийг хамгаалах талаар уриалан ажиллалаа.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад шинэ жилийн баярын үйл ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой хүнсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хоол хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор зөвлөмж боловсруулан гарын авлага, брошурын хамт тараан хяналт тавьж ажиллалаа.

Сант сум

Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2023 оны тооллогыг 2023 оны 12-р сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 21-ний өдрийн хооронд зохион байгуулж тооллогод 12 чиглэлд 39 албан хаагч ажиллалаа. Жилийн эцсийн мал тооллогоор 480 өрхөд нийт 99069 мал тоологдсоноос адуу 7123, үхэр 16737, хонь 47372, ямаа 27837 байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын дагуу ёслолын үйл ажиллагаа явагдаж 3 албан хаагч тангараг өргөж, 18 албан хаагч оролцож хүндэтгэл үзүүллээ.

Хүүхэд өсвөр үеийнхний дуу хоолойг сонсох, санал санаачилгыг хэрэгжүүлэхэд тэдний оролцоог хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн санаа

бодол, тулгамдсан асуудлуудыг хүргэж, төрийн бодлогод тусгуулан шийдвэрлүүлэх зорилгоор сумын “Хүүхдийн чуулган-2023”, “Хүүхдээ сонсьё” арга хэмжээг сумын ИТХ, ЗДТГ, ЕБС хамтран 11 дүгээр сарын 28-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Хүүхдийн чуулганд 8-12 дугаар ангийн 105 сурагч, 8 багш, 4 төрийн албан хаагч оролцлоо. Уг арга хэмжээний үеэр 16 нас хүрсэн сурагчдын дунд “Иргэний андгай” өргүүлэх ёслолыг зохион байгуулж 37 сурагч хамрагдлаа.

Авлигын эсрэг болон Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан сурагч, хүүхэд багачуудад авлига, шударга ёсны тухай ойлголт өгөх, авлигыг үл тэвчих хандлага, ёс зүйг төлөвшүүлэх, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын агуулгыг тайлбарлан таниулсан хичээлийг нэгдсэн журмаар зохион байгуулж заахыг боловсролын сургалтын байгууллагад үүрэг болголоо. Үүний дагуу ЕБС-ийн түүх, нийгмийн ухааны багш 7-11-р ангийн 126 сурагчдад хүний эрх, хүний эрхийн тэмцлийн талаар хичээл заалаа. Мөн анги удирдсан багш нар ангийн ажлын цаг дээрээ сургалт зохион байгууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын тэмдэглэлт өдрийг угтаж "ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛД ХААЛГАА НЭЭЭ" өдөрлөг арга хэмжээ болон үзэсгэлэн худалдааг 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгууллаа.

Сүхбаатар сум

2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр "Сүхбаатар хотын хөгжилд бизнес эрхлэгч залуучуудын оролцоо, хамтын ажиллагаа" чуулганыг “Бэст” Хөтөлбөр, Каритас Чех Републик Олон улсын байгууллагууд хамтран Сүхбаатар хотод зохион байгуулж ажил хөдөлмөр эрхлэхэд залуучуудад тулгамдаж буй асуудлаа тодорхойлох, залуучуудынхаа дуу хоолойг сонсох, харилцан санал солилцох, төрөөс хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр, бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг танилцуулах, хотын хөгжилд залуучуудын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор чуулга уулзалтыг зохион байгуулсан. Зөвлөгөөн чуулганы үйл ажиллагаанд аймаг, сумын удирдлагууд, бизнес эрхлэгч залуучууд, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, банк санхүүгийн болон олон улсын байгууллагын нийт 140 гаруй төлөөллүүд оролцсон.

“Мал, амьтны гоц халдварт гахайн африк мялзан, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд нэгдсэн хогийн цэг болон гахай бүхий айл өрхүүдэд ариутгал, халдваргүйтгэл хийх, мал амьтны сэг зэм устгах ажлыг зохион байгуулж гахай бүхий 22 өрхийн 32820 м.кв талбайд ариутгал халдваргүйтгэл хийж хогийн нэгдсэн цэгт болон ойр орчимд 230 гаруй мал, амьтны сэг зэмийг цуглуулан устгалын цэгт зааврын дагуу булшилсан.

2023 оны жилийн эцсийн байдлаар тооллогод 346 өрх, 2 аж ахуй нэгж байгууллагын нийт 17835 толгой мал тоологдсон ба үүнээс тэмээ 3, адуу 3088, үхэр 5621, хонь 3974, ямаа 5149 тус тус тоологдлоо.

Түшиг сум

Үр тарианы хураалт 100%-тай явагдаж дууслаа. 5151 га талбайд хураалт хийснээс нэгж талбайгаас 14 цн буюу 9952,9 тн үр тариа, улаан буудай 6961 га талбайгаас хураалт хийснээс нэгж талбайгаас 14 цн буюу 9650,9 тн, овьёос 262 га талбайгаас 302 тн, тэжээлийн ургамал 4016 га талбайгаас 3400 тн, рапс 1260 га талбайгаас 569,5 тн хураан авсан байна.

Төрийн албан хаагчдын дунд “Үндэсний бичгээ сурах, хэрэглэх” олон талт ажлын төлөвлөгөөг гарган Түшиг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж нийт 5 төрлийн уралдаан тэмцээнд давхардсан тоогоор 90 орчим албан хаагчийг хамруулаад байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 1 аж ахуй нэгж, 196 өрхийн 22299 толгой үхэр, гахай 102 толгой гахай нийт 22401 толгой мал тус тус хамруулсан.

Сайхан бичигтэн төрийн албан хаагч нийт-21 оролцогч, цахим сорилгын уралдаан-16 оролцогч, цахим уншлагын уралдаанд-17 оролцогч тус тус оролцож байгууллагын танилцуулгыг гараар болон цахим постер хийж уралдахад 4 байгууллага хамрагдлаа.

Хушаат сум

2023 онд Хууль, эрх зүй, хандлага харилцааны талаар төрийн албан хаагчдын дунд нийт 10 сургалт зохион байгуулж 195 албан хаагчид хамрагдлаа.

Иргэдийн хүлэмжийн аж ахуй эрхлэх, өрхийн хэрэгцээний хүнсний ногооны тариалалт хийж, өрхийн орлого нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Нарлаг ган хүлэмж” ХХК-аас ирүүлсэн үнийн саналыг тариаланч, ногоочдод гарын авлагаар 18 иргэнд, цахим хуудсаар-258 иргэн уншиж танилцсан байна.

Төмс, хүнсний ногооны зоорь, агуулахын судалгааг гарган 12 ААН-ийн энгийн хийцтэй 9160 тн багтаамжтай агуулах, төмс хүнсний ногооны 6 ААН-ийн 1245 тн багтаамжтай зоорь, сумын 120 тн багтаамжтай 2 зоорь байна. 24 Аж ахуй нэгж, 62 ногоочдын урамшууллын хүсэлт илгээж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Монгол улсын 16 нас хүрч байгаа өсвөр үеийн залуучуудад түүх соёлоо дээдэлсэн, эх оронч үзэлтэй, төр улсаа эрхэмлэн дээдэлсэн, эх орон ард түмнийхээ өмнө үүрэг хариуцлага хүлээсэн иргэн болгон төлөвшүүлэх зорилготой Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 21 дах удаагаа зохион байгуулагдаж байгаа “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг 2023 оны 11 сарын 27-д сумын Соёлын төвд амжилттай зохион байгууллаа. Нийт 12 сурагч оролцон иргэний андгай өргөн батламж үнэмлэхээ гардан авлаа.

Хүүхдийн үзэл бодол, дуу хоолойг сонсож, санал санаачилгыг сум орон нутгийн бодлого шийдвэрт тусгах. Хүүхдэд тулгамдаж буй асуудлуудыг сонсон, тэдний оролцоотойгоор хамтран шийдвэрт хүрэх. Сурагчдын мэдлэг боловсролыг нэмэгдүүлэхэд зорилгоор сумын “Нэгдүгээрт хүүхэд” хүүхдийн чуулганыг 2023 оны 11 дүгээр сарын 27-д сумын Соёлын төвд 4-12 дугаар ангийн нийт 50 сурагч оролцож амжилттай зохион байгууллаа.

Хүдэр сум

Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогыг хөдөөгийн 4 чиглэлд 8 тоологч, төвийн 10 хэсэгт 20 тоологч явж тооллогын ажлыг цаг хугацаанд нь явуулж хуваарийн дагуу хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна. 2023 оны жилийн эцэст 37652 тоо толгой мал тоологдсоноос адуу 5581, үхэр 12932, хонь 11139, ямаа 8000 байна. 2022 оны жилийн эцсийн малын тоотой харьцуулахад хонь, ямаа буурсан үхэр, адуу өссөн үзүүлэлт гарсан.

2023 онд ойн сангийн нөөцгүй сумдын түлээний мод бэлтгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулан, мод бэлтгэлийн талбай тусгаарлалтыг 56 га талбайд хийж Сүхбаатар сум 8550м3 түлээний мод бэлтгэхээс 1495 м3 бэлтгэж 17,4

хувь, Шаамар сум 1000м³ түлээний мод бэлтгэж 100 хувь, Жавхлант сум 500м³ түлээний мод бэлтгээгүй байна.

Тайлант сард соёл урлагийн захиалгат 5 арга хэмжээ зохион байгуулж нийт 434 иргэн хамрагдсан байна. Үндэсний хөгжим морин хуурын дугуйланд 25 сурагч, даралтад хөгжмийн дугуйланд 6 сурагч нийт 31 сурагч дугуйланд хамрагдсан байна. Бүжгийн дугуйланд 19 сурагч суралцаж байна.

Номын сангаар 43 уншигч 51 номоор үйлчлүүлсэн байна. Үүнээс насанд хүрсэн уншигч 33, хүүхэд 10 тус тус үйлчлүүлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн арван зургаан нас хүрсэн 17 сурагчийг “Иргэний андгай” өргүүлэх мөн 7-12 дугаар ангийн нийт 70 хүүхдийг оролцуулан “Бидний оролцоо бидний ирээдүй” сэдвээр зохион байгуулж, сурагчдаас сургуулийн хүрээнд тулгамдаж буй 12 асуудал дэвшүүлснийг сургуулийн захиргаанд хүргүүллээ.

Цагааннуур сум

Сумын хэмжээнд мал тооллогыг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулж урьдчилсан тоогоор нийт 658 өрхийн 167104 мал тоолуулсан байна. Үүнээс: Адуу- 7378, үхэр-24943, хонь-77248, ямаа-57535 тус тус тоолуулсан.

Намрын ургац хураалтад:

-Улаанбуудай 20989 га-д тариалалт хийж 20455 га талбайг хураан авч 1га-с 13,7цн буюу 28057 тн,

-Арвай 282 га-с 7,7цн буюу 219 тн,

-Овьёос 1275 га-с 2,5цн буюу 320,95 тн,

-Тэжээлийн ургамал 6904 га-с 13,7цн буюу 9516 тн,

-Тосны ургамал 9534 га-с 6,68 цн буюу 6327 тн,

-Төмс 10,45 га-с 58,2 цн буюу 60,8тн,

-Хүнсний ногоо 47,8 га-с 47,6цн буюу 228 тн ургац тус тус хураан авсан байна.

Сумын төсвийн хөрөнгөөр “2 дугаар цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх”- ажлыг “Шимт боловсрол” ХХК 100 хувь хүлээлгэн өглөө, “Соёлын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх”- ажил 100 хувьтай явагдаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжиж буй сумын төв доторх 1,5 км засмал зам тавих ажлыг “Сэлэнгэ АЗЗА” ХК гүйцэтгэж, ажлын явц 100 хувийн гүйцэтгэлтэй, Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг “Девсофт” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шаамар сум

2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, худаг, усны тооллогыг 2023 оны 12 дугаар сарын 07-10-ны хооронд зохион байгуулан тайлан мэдээг нэгтгэн аймгийн Статистикийн газарт хүлээлгэн өгсөн.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР